

ҮНДЭСНИЙ ТҮҮХ, СОЁЛ, УЛАМЖЛАЛЫН НЭВТРҮҮЛЭГ, ХҮҮХДИЙН НЭВТРҮҮЛЭГ, ТАНИН МЭДЭХҮЙН НЭВТРҮҮЛЭГ НЭВТРҮҮЛСЭН ТАЙЛАН /2024 он/

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30.1.6, 30.1.8-д заасан чиг үүргийн хүрээнд радио, телевизийн хөтөлбөрт тавигдах дараах шаардлагыг Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд заасан зарчим, тус хуулийн 23, 24 дүгээр зүйлд заасан үзүүлэлтүүдийн хүрээнд батлан гаргаж, хэрэгжилтэд хяналт, мониторинг хийж байна. Тус хорооны 2021 оны 01 тоот тогтоолоор батлагдсан “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.10, 3.12 дахь заалтуудын дагуу Монгол Улсад болон орон нутагт хамрах хүрээтэй өргөн нэвтрүүлгийн телевизүүдэд, 2020 оны 87 тоот тогтоолоор баталсан “Радиоогийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.10 дахь заалтын дагуу радиоогийн үйлчилгээ эрхлэгчдэд үндэсний түүх, соёл, уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлэг, бэлтгэн нэвтрүүлэх үүрэг хүлээлгэн, радио, телевизийн хөтөлбөрт хийдэг байнгын хяналт, мониторингийн тайланд үндэслэн улирал тутам хэрэгжилтэд нь үнэлгээ дүгнэлт гарган ажиллаж байна.


Түүнчлэн тус хорооноос өргөн нэвтрүүлгийн хөгжил, үндэсний бүтээл үйлдвэрлэлийг дэмжих ажлын хүрээнд 2024 оны 1-р сард телевиз, радиоогийн үйлчилгээ эрхлэгч дунд Үндэсний түүх, соёл, уламжлал, танин мэдэхүй, хүүхдийн нэвтрүүлгийн шилдэг бүтээлийн уралдааныг зарлаж, 11-р сард дүгнэсэн. Уралдаанд Улаанбаатар хот болон орон нутгаас 33 телевиз, 12 радио оролцож, нийт 171 бүтээл, нэвтрүүлэг ирүүлснийг радио, телевизүүдийн хөтөлбөрт Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн дагуу тавьдаг монгол бүтээлийн хувь хэмжээ, үндэсний түүх, соёл уламжлал, танин мэдэхүйн болон хүүхдийн нэвтрүүлгийн цагийн шаардлагуудыг хангасан байдал, уралдааны төрөл ангилал, сэдэвт тохирсон байдал, дуу, дүрсний мэргэжлийн түвшин зэрэг үзүүлэлтүүдээр мэргэжлийн, хөндлөнгийн шүүгчдийн бүрэлдэхүүн шүүж, шилдэг бүтээлүүдийг шалгаруулан олон нийтэд мэдээлж ажиллалаа.

Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизүүд 2024 онд үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлгийг дараах байдлаар нэвтрүүлжээ.

1. УЛААНБААТАР ХОТЫН ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ТЕЛЕВИЗ

Монгол Улсын нутаг дэвсгэрт хамрах хүрээтэй өргөн нэвтрүүлгийн телевиз нь жилд 200 цагаас багагүй үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг бэлтгэн нэвтрүүлэх үүрэгтэй бөгөөд 2024 онд өргөн нэвтрүүлгийн 18 телевизээр нийт 3745 цагийн нэвтрүүлэг нэвтрүүлсэн нь өнгөрсөн оноос 446 цагаар өссөн үзүүлэлттэй байна. Телевиз тус бүрээр харахад ТВ8 телевиз нь тус онд хамгийн их цагийн буюу 637 цагийн нэвтрүүлэг нэвтрүүлжээ. Мөн Централ, Малчин, ТВ5, Монгол HD, Боловсрол суваг, ТМ

телевизүүд нь өнгөрсөн оноос тодорхой хэмжээнд хувь, хэмжээг нэмэгдүүлсэн нь тус хорооноос батлан гаргасан “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.10.1 дэх заалтын хэрэгжилтийг бүрэн хангаж байна.




Үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг нэвтрүүлсэн нийт цаг		
Нийт ТВ тоо	2023 он /цаг/	2024 он /цаг/
18 телевиз	3299:32:13	3745:04:50

1.2 Монгол Улсын нутаг дэвсгэрт хамрах хүрээтэй өргөн нэвтрүүлгийн телевиз жилд 180 цагаас багагүй танин мэдэхүйн нэвтрүүлэг бэлтгэн нэвтрүүлэх үүрэгтэй бөгөөд 2024 онд УБ хотын өргөн нэвтрүүлгийн 18 телевиз нийт 5063 цагийн танин мэдэхүйн нэвтрүүлэг нэвтрүүлсэн нь өнгөрсөн оноос 1010 цагаар өсжээ. Танин мэдэхүйн нэвтрүүлгийг Боловсрол суваг, Стар, Сүлд, ТМ телевизүүд бүтээл үйлдвэрлэлт болон тус төрөл жанрын нэвтрүүлэгт түлхүү анхаарч, өмнөх жилээс олон цагаар нэвтрүүлсэн ба эдгээр телевиз болон Ийгл, 25-р суваг, ETV, Централ телевизүүд нь “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.10.4 дэх заалтын хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна.

Түүнчлэн 2024 онд танин мэдэхүйн нэвтрүүлгийг Монгол Улсын нутаг дэвсгэрт хамрах хүрээтэй өргөн нэвтрүүлгийн болон арилжааны 30 телевизээр 725:39:27 цагийн дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлсэн бол 1307:55:22 цагийн хадмал тайлбартайгаар нэвтрүүлжээ. Энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад дохионы хэлний хэлмэрчтэй танин мэдэхүйн нэвтрүүлэг 58 цагаар, хадмал тайлбартай нэвтрүүлсэн нэвтрүүлэг нь 700 цагаар өссөн. Энэ нь тус хорооноос Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.4, Телевизийн хөтөлбөрт тавих шаардлагын 3.17-д заасан хадмал тайлбар, дохионы хэл бүхий нэвтрүүлгийн хувь хэмжээг тодорхойлох чиг үүргийн дагуу Монгол Улсад хамрах хүрээтэй телевизүүдэд мэдээ, мэдээллийн хөтөлбөр, хүүхдийн болон танин мэдэхүйн нэвтрүүлгийг дохионы хэлмэрчтэй эсхүл

хадмал тайлбартай гаргах үе шаттай төлөвлөгөөг өөрийн боломжид тулгуурлан редакцын бодлогын хүрээнд төлөвлөж, төлөвлөгөөний дагуу гаргах үүргийг хүлээлгэн биелэлтэд хяналт тавин ажилласны үр дүн гэж үзэж болохоор байна.





Танин мэдэхүйн нэвтрүүлэг нэвтрүүлсэн нийт цаг		
Нийт ТВ тоо	2023 он /цаг/	2024 он /цаг/
18 телевиз	4053:19:43	5063:29:06

1.3. “Монгол Улсын нутаг дэвсгэрт хамрах хүрээтэй өргөн нэвтрүүлгийн телевиз нь хүүхдийн нас, бие, сэтгэхүйн онцлогт тохирсон хүүхдийн хөгжил, хүмүүжил, төлөвшилд чиглэсэн танин мэдэхүйн боловсрол балчир буюу 3+ насны ангилалтай нэвтрүүлэг жилд 90 цагаас багагүй, бага, өсвөр насны буюу 6+, 12+ насны ангилалтай нэвтрүүлэг жилд 130 цагаас багагүй хугацаагаар нэвтрүүлнэ” гэж заасан. Үүний дагуу 2024 онд Өргөн нэвтрүүлгийн 18 телевиз балчир нас буюу 3+ насны ангиллын 1377 цагийн, бага нас 6+ болон өсвөр нас 12+ насны ангилалтай 2165 цагийн нэвтрүүлгийг нэвтрүүлсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 400 болон 200 цагаар өссөн үзүүлэлт юм. Тухайлбал, NTV, С1, Сүлд телевизүүд нь балчир нас буюу 3+ нэвтрүүлгийг өнгөрсөн оныхоос олон цагаар нэмэгдүүлсэн ба эдгээр телевизээс гадна ТМ, Малчин, Боловсрол суваг, Монгол HD, ТВ5, Стар телевизүүд “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.10.3 дахь заалт буюу балчир нас буюу 3+ нэвтрүүлгийг цагийг бүрэн хангаж ажилласан байна.

Харин бага нас 6+ болон өсвөр нас 12+ насны ангиллын нэвтрүүлгийн хувьд ЕТВ, NTV, Монгол HD, С1 телевизүүд өнгөрсөн онд нэвтрүүлсэн цагийг нэмэгдүүлэн бол ТВ8, ТВ5, Боловсрол суваг, ТМ телевизүүдийн цаг багасжээ. Централ ТВ, Ийгл, Тэнгэр телевизүүд хүүхдийн нэвтрүүлэг огт нэвтрүүлээгүй нь “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.10.2, 3.10.3 дахь заалтуудын хэрэгжилтийг огт хангахгүй байгаа ба

цаашид хүүхдэд зориулсан нэвтрүүлэг бүтээх, нэвтрүүлэх талаар анхаарч ажиллах шаардлагатай гэж үзлээ.


Түүнчлэн хүүхдэд зориулсан нэвтрүүлгийг 2024 онд 8 телевизээр 112:26:12 цагийн дохионы хэлний хэлмэрчтэй, 7 телевизээр 200:53:18 цагийн хадмал тайлбартай бэлтгэн нэвтрүүлжээ. Энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлэг 32 цагаар, хадмал тайлбартай нэвтрүүлсэн нэвтрүүлэг 80 цагаар өссөн үзүүлэлттэй байна.



Хүүхдийн нэвтрүүлэг нэвтрүүлсэн нийт цаг /+3 нас, +6 болон +12 нас /				
Нийт ТВ тоо	Балчир нас +3 2023 он /цаг/	Балчир нас +3 2024 он /цаг/	Бага, өсвөр нас +6, +12 2023 он /цаг/	Бага, өсвөр нас +6, +12 2024 он /цаг/
18 телевиз	978:19:38	1377:06:14	1904:02:36	2165:07:32

2. ОРОН НУТГИЙН ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ТЕЛЕВИЗ


2.1 “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.12.1-д заасны дагуу Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа өргөн нэвтрүүлгийн телевиз нь жилд 180 цагаас багагүй хугацааны үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг бэлтгэн нэвтрүүлэх үүрэгтэй байдаг. Тус хороо нь орон нутгийн телевизүүдийн хөтөлбөрт түүврээр буюу улиралд 15, жилд давхардсан тоогоор 45 телевизийн хөтөлбөрт хяналт мониторинг хийдэг. Энэхүү хяналт, мониторингийн дүнгээр 2023 онд орон нутгийн өргөн нэвтрүүлгийн 36 телевизээр 2099 цагийн нэвтрүүлэг нэвтрүүлсэн бол 2024 оны жилийн эцсийн байдлаар өргөн нэвтрүүлгийн 38 телевизээр 1931 цагийн нэвтрүүлэг нэвтрүүлжээ. Орон нутгийн телевизүүдийн үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлгийн цаг жил, жилээр ялгаатай гарч байгаа нь мониторингд түүврээр хамрагддагаас гадна 2024 онд Монгол Улсын Их хурлын ээлжит сонгууль болсонтой холбоотойгоор телевизүүд хөтөлбөртөө сонгуулийн сурталчилгааны цагийг түлхүү төлөвлөсөн зэргээс шалтгаалж байна. Дээр дурдсанчлан орон нутгийн телевизүүдийн хувьд жилийн туршид мониторингд хамрагддаггүй ба түүврээр хяналт, мониторинг хийгддэг тул жилийн нийлбэр цагаар хөтөлбөрийн шаардлага хангасан эсэхийг дүгнэх боломжгүй юм.



Үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлгийн цаг			
Орон нутгийн телевизийн тоо	2023 он /цаг/	Орон нутгийн телевизийн тоо	2024 он /цаг/
36	2099 цаг	36 телевиз	1931 цаг

2.2 Танин мэдэхүйн нэвтрүүлэг

“Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.12.3-т заасны дагуу орон нутгийн өргөн нэвтрүүлгийн телевиз нь жилд 90 цагаас багагүй хугацааны танин мэдэхүйн нэвтрүүлгийг бэлтгэн нэвтрүүлэх үүрэгтэй бөгөөд 2023 онд 34 телевизээр 1553 цагийн нэвтрүүлэг нэвтрүүлсэн бол 2024 оны жилийн эцсийн байдлаар 42 телевизээр 1842 цагийн нэвтрүүлэг нэвтрүүлсэн байна. Энэ нь өмнөх оны нэвтрүүлгийн цагтай харьцуулахад 289 цагаар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Тухайлбал 2023 онд Орхон аймгийн NBTV телевиз 11 цагийн, Архангай аймгийн Тамир телевиз 38 цагийн нэвтрүүлэг нэвтрүүлж байсан бол энэ онд NBTV телевиз 218 цагийн, Тамир телевиз 155 цагийн нэвтрүүлэг нэвтрүүлсэн байгаа нь танин мэдэхүйн нэвтрүүлэг, бүтээл үйлдвэрлэлтэд түлхүү анхаарч ажиллаж байгаа нь харагдаж байна.



Танин мэдэхүйн нэвтрүүлгийн цаг			
Орон нутгийн телевизийн тоо	2023 он /цаг/	Орон нутгийн телевизийн тоо	2024 он /цаг/
34	1553 цаг	42 телевиз	1842 цаг

2.3. Хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн цаг

Орон нутгийн өргөн нэвтрүүлгийн телевиз нь хүүхдийн нас, бие, сэтгэхүйн онцлогт тохирсон хүүхдийн хөгжил, хүмүүжил, төлөвшилд чиглэсэн танин мэдэхүйн боловсрол олгох нэвтрүүлгийг жилд 150 цагаас багагүй хугацаанд бэлтгэн нэвтрүүлэх үүрэгтэй. Орон нутгийн телевизүүдийн хувьд 2023 онд 33 телевизээр 1884 цагийн хүүхдийн нэвтрүүлэг нэвтрүүлсэн бол 2024 оны жилийн эцсийн байдлаар 38

телевизээр 2120 удаагийн давталттай 1319 цагийн хүүхдийн нэвтрүүлэг нэвтрүүлсэн байна.



Хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн цаг			
Орон нутгийн телевизийн тоо	2023 он /цаг/	Орон нутгийн телевизийн тоо	2024 он /цаг/
33	1884 цаг	38	1319 цаг

3. РАДИОГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ

3.1. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 87 дугаар тогтоолоор батлагдсан “Радиогийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.10-т заасны дагуу радио нь жилд 360 цагийн үндэсний түүх, соёл, уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлэг бэлтгэн хүргэх үүрэгтэй. Тус хорооноос Улаанбаатар хотын арилжааны 30 радиогийн хөтөлбөрт түүврээр хяналт, мониторинг хийж, тайланд үндэслэн улирал тутам дээрх үүргийн хэрэгжилтийн байдалд үнэлгээ дүгнэлт гарган ажиллаж байна. 2023 оны жилийн эцсээр нийт 30 радио 6786 цагийн үндэсний түүх, соёл, уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлэг бэлтгэн нэвтрүүлсэн бол 2024 оны жилийн эцсийн байдлаар 29 радиогоор 9658 цагийн үндэсний түүх, соёл, уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлэг нэвтрүүлсэн нь өмнөх оноос 2872 цагаар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.



Үндэсний түүх, соёл, уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлгийн цаг			
Улаанбаатар хотын радиогийн тоо	2023 он /цаг/	Улаанбаатар хотын радиогийн тоо	2024 он /цаг/
30	6786 цаг	29	9658 цаг

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО
2025 он